



ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Х.ПҮРЭВЖАРГАЛ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/712

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нийт 891,552.8 сая төгрөгийн төсөв өртөгтэй 36 төсөл, арга хэмжээнд техник технологийн хяналтын ажлыг гүйцэтгэж, 53,374.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээг бүрэн гүйцэтгэж, дууссан бөгөөд 835,214.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээ он дамжиж, 2024 онд үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Газар чөлөөлөлтөөс шалтгаалан 1 зам барилгын ажил хэрэгжээгүй байна.

Аудитын гол асуудал

Олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөр хураах 31 цэгээс Улаанбаатар хот орчмын Эмээлт, Түргэний гүүр, Хөшгийн хөндий, Хоолт, Налайх Тэрэлж төлбөр авах цэгүүдийн үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн бүрэн цахимжуулж, 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс Баруун турууны төлбөр авах цэгийн үйл ажиллагааг цахим төлбөрийн системээр эхлүүлсэн байна. Хөдөө орон нутаг дах 26 төлбөр авах цэгийг цахимжуулахад шаардагдах интернэтийн эх үүсвэрт холбох, шилэн кабель татах ажлын гүйцэтгэл 75 хувийн гүйцэтгэлтэй, 19 төлбөр авах цэгийг холбон ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 96 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


B. M. Ц.НАРАНЧИМЭГ